

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР ХОТ ДАХЬ
ГААЛИЙН ГАЗРЫН ДАРГА
Д.СОЛОНГО ТАНАА

2019.02.25 № 06/325
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Улаанбаатар хот дахь Гаалийн газрын дарга Д.Солонго Таньд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 28-наас 2019 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Нийслэл аудит ХХК-ийн аудитор Д.Ариунбулган, чанарын хяналтын менежер Б.Хөхөө, аудиторын туслах Д.Доржпүрэв нар хариуцаж хэрэгжүүлэв.

Улаанбаатар хот дахь Гаалийн газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Нийслэл аудит ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/38 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Улаанбаатар хот дахь Гаалийн газар нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Улаанбаатар хот дахь Гаалийн газар нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодохойлжээ. Үүнд:

- Гадаад худалдааг хөнгөвчлөх
- Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх
- Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах
- Улсын төсвийн орлогыг шудрага үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх
- Гаалийн байгууллага дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан

бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл байгуулах тухай конвенц
- Барааг тодорхойлох кодлох уялдуулсан системийн тухай олон улсын конвенц
- Тир карнейг хэрэглэн барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай конвенц
- Барааг түр хугацаагаар оруулах тухай конвенц
- Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц
- Хуурай боомтын тухай засгийн газар хоорондын хэлэлцээр
- Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенц

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Улаанбаатар хот дахь Гаалийн газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програм хангамж ашигладаг байна.

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Улаанбаатар хот дахь Гаалийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болгосон санхүүгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус газрын хувьд нийт зардлын хэмжээ үйл ажиллагааны цар хүрээг илтгэх тохиромжтой үзүүлэлт гэж үзсэнтэй холбоотой юм.

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2018 оны *нийт зардал* 5,605,460.3 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 112,109.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	2,565.4	
	Дүн	0	2,565.4	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг Гаалийн газрын удирдлагад танилцуулж Аудитын үр дүнг танилцуулсан талаарх мэдээлэл Г301 маягтаар баталгаажууллаа.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус газар нь Сангийн сайдын 2018 оны 207 тоот тушаалын дагуу Хөрөнгийн дахин үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулан ажилласан боловч уг газрын өмчлөлд бүртгэлтэй барилгыг Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтэд үндэслэн дараахь ашиглалтын гэмтэлтэй байгаа гэсэн шалтгаанаар хөрөнгийн дахин үнэлгээ хийгдээгүй байна. Үүнд:

- Ашиглалтын болон байгалийн хүчин зүйлээс хамаарч хэвийн хэмжээнээс илүү ан, цав үүсэж, эвдрэл гэмтэл үүссэн.
- Барилгын 1, 2 дугаар давхарын чулуу фасаднаас дээшээ өнгөлгөөний шавардлагатай фасаданд олон жилийн ашиглалтын хугацаанд хагарал их хэмжээгээр үүссэн.
- 7 дугаар давхарт байрлах хурлын танхим болон оффисын өрөө тасалгааны агааржуулалтын системийн анхны зураг төслийн дагуу холболтуудыг бүрэн угсраагүйгээс гадна ханын өргийн зузаан нь зураг төсөл дээр 360 мм-ийн хөнгөн блок хана байсныг 250 мм-ийн хана болгон өөрчилсөн зэрэг болно.

Мөн тайлант онд цалин хөлс, нэмэгдэл, НДШ-ийн зардалд нийт урсгал зардлын 55.1 хувь буюу 3,460,425.6 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн зэрэг асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой нэг хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 3,693,615.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 3,650,704.4 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь нийт дүнгээр төсвийн зардлыг 1,9 хувиар буюу 72,910.6 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Энэ

нь Засгийн газрын тогтоолыг мөрдлөг болгон байгууллагын үйл ажиллагааг төсвийн хуваарийн дагуу хэмнэлттэй зарцуулах горимд шилжин ажиллана гэсэнтэй нийцэж байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Улаанбаатар хот дахь Гаалийн газар нь шилэн дансны тухай хуулийн мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх, хуулийн хугацаанд нууцад хамруулсанаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх зарчмын дагуу, шилэн дансны стандартыг баримтлан шилэн дансны сайтад мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв оруулж дараах мэдээг хүргэсэн байна. Үүнд:

1. Бүтэн жилээр оруулах мэдээлэл хэсэгт 10 удаа
2. Хагас жилээр оруулах мэдээлэл хэсэгт 4 удаа
3. Сар бүр оруулах мэдээлэл хэсэгт 35 удаа
4. Улирал бүр оруулах мэдээлэл хэсэгт 3 удаа
5. Тухай бүр оруулах мэдээлэл хэсэгт 78 удаа

Нийт 130 мэдээг хуулийн хугацаанд PDF, Excel, XML форматаар “Цахимаар мэдээллийг оруулна” гэж заасан тодорхой маягтын дагуу шилэн дансны нэгдсэн сайт <https://shilendans.gov.mn/org/695> цахим хуудсанд тайлангийн мэдээллийг шивж оруулан нийтэд мэдээлж байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжөөс нэгийг бүрэн биелүүлж Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ өөрчлөлт оруулах гэсэн зөвлөмжийн дагуу Гаалийн ерөнхий газраас бэлтгэсэн системийн хэмжээнд ашиглаж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийнталаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Улаанбаатар хот дахь Гаалийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант оны эцэст НДШ-ийн тайлангаар 2,565.4 мянган төгрөгийн илүү төлөлттэй байгаа бөгөөд уг авлагыг санхүүгийн тайланд бусад байгууллагаас авах авлагаар тусгасан байна. Энэ нь тайлант хугацааны эцэст Нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс үүссэн байна.

Энэ нь Оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, тайлант үеийн үр дүн буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг холбогдох стандарт, хуулийн дагуу үнэн зөв тооцож байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дуусвар болсон санхүүгийн тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>56,273,389.55</u>	<u>69,777,756.61</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	2,565,446.86
335	Бусад авлага	-	2,565,446.86
3351	Байгууллагаас авах авлага		2,565,446.86
35	БАРАА МАТЕРИАЛ	56,273,389.55	67,212,309.75
351	Түүхий эд материал	-	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	30,224,141.75	29,083,165.35
354	Хангамжийн материал	26,049,247.80	38,129,144.40
35410	Бичиг хэргийн материал	1,776,350.00	4,641,940.00
35420	Аж ахуйн материал	18,544,150.00	26,783,456.60
35440	Түлш, шатах тослох материал	330,000.00	1,305,000.00
35470	Бусад хангамжийн материал	5,398,747.80	5,398,747.80
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,270,791,576.46</u>	<u>9,732,203,892.48</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,270,791,576.46	9,732,203,892.48
391	Газар		96,298,120.00
392	Биет хөрөнгө	11,270,275,951.46	9,635,905,772.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,816,915,170.00	4,930,334,929.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	421,197,999.84	519,878,292.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	140,312,170.00	158,112,170.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	93,791,336.81	80,513,558.95
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,074,587,419.50	7,058,460,138.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	368,031,896.64	2,018,715,699.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	327,845,798.06	345,514,332.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	221,030,039.37	250,074,912.72
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	5,333,333.44	7,333,333.48
393	Биет бус хөрөнгө	515,625.00	-
39301	Програм хангамж	3,200,000.00	3,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	2,684,375.00	3,200,000.00
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>11,327,064,966.01</u>	<u>9,801,981,649.09</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>172,377.43</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	172,377.43
413	Өглөг	-	172,377.43
4136	Бусад өглөг	-	172,377.43
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	172,377.43
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>11,327,064,966.01</u>	<u>9,801,809,271.66</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	11,327,064,966.01	9,801,809,271.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,753,678,238.38	6,849,976,358.38
512	Хуримтлагдсан үр дүн	4,571,936,504.78	2,950,382,690.43
51210	Өмнөх үеийн үр дүн	4,571,936,504.78	4,571,936,504.78
51220	Тайлант үеийн үр дүн		-1,621,553,814.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,450,222.85	1,450,222.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>11,327,064,966.01</u>	<u>9,801,981,649.09</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,803,494,085.26	4,004,999,721.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,376,796,485.26	311,384,721.43
120	Нийтлэг татварын бус орлого	7,376,796,485.26	311,384,721.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,317,942,485.26	264,035,627.43
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	7,317,942,485.26	264,035,627.43
120005	Түрээсийн орлого	58,854,000.00	47,349,094.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,426,697,600.00	3,693,615,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,426,697,600.00	3,693,615,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,420,697,600.00	3,693,615,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	6,000,000.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,709,995,065.53	5,605,460,313.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,709,995,065.53	5,605,460,313.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,645,878,722.10	5,514,794,065.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,970,293,515.24	3,088,789,738.94
210101	Үндсэн цалин	2,852,743,915.24	2,967,913,738.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	117,549,600.00	120,876,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	327,382,772.44	369,251,360.89
210201	Тэтгэврийн даатгал	210,078,359.12	246,438,338.94
210202	Тэтгэмжийн даатгал	23,460,883.29	24,562,604.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	29,326,103.07	30,703,255.37
210204	Ажилгүйдлийн даатгал	5,865,220.46	6,140,650.64
210205	Эрүүл мэндийн даатгал	58,652,206.50	61,406,511.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,584,687.89	51,690,339.26
210301	Гэрэл, цахилгаан	31,893,909.00	33,420,826.00
210302	Түлш, халаалт	15,495,954.00	14,564,283.00
210303	Цэвэр, бохир ус	3,194,824.89	3,705,230.26
2104	Хангамж, бараа материалын зардал	24,385,595.36	30,220,638.94
210401	Бичиг хэрэг	4,219,780.00	10,080,150.00
210402	Тээвэр, шатахуун	6,393,500.00	6,049,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,305,302.36	3,192,337.94
210404	Ном, хэвлэл	6,703,500.00	4,668,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	780,000.00	710,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,983,513.00	5,520,551.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,143,322.00	21,797,108.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	263,984.00	139,600.00
210604	Урсгал засвар	8,879,338.00	21,657,508.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,625,960.87	105,770,317.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,150,789.87	31,571,691.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	3,900,000.00

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	2,407,500.00	2,652,290.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	97,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	511,960.00	661,426.00
210807	Газрын төлбөр	261,700.00	261,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	53,294,011.00	66,626,210.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	178,462,868.30	1,847,274,561.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,352,801.00	4,709,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	78,100.00	125,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	174,031,967.30	1,842,440,561.69
212	ТАТААС	17,711,700.00	-
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	17,711,700.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,404,643.43	90,666,248.54
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,404,643.43	90,666,248.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,404,643.43	90,666,248.54
226001	Гадаад эх үүсвэрээр		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ= ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>7,093,499,019.73</u>	<u>-1,600,460,592.23</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	26,165,016.74	21,093,222.12
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	24,193,816.74	871,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,971,200.00	20,222,222.12
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-26,165,016.74	-21,093,222.12
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>7,067,334,002.99</u>	<u>-1,621,553,814.35</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дуусвар болсон санхүүгийн тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,485,551,600.00</u>	<u>3,761,663,112.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,854,000.00	68,048,112.00
120	Нийтлэг татварын бус орлого	58,854,000.00	68,048,112.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	406,550.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	406,550.00
120005	Түрээсийн орлого	58,854,000.00	67,641,562.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,426,697,600.00	3,693,615,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,420,697,600.00	3,693,615,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,420,697,600.00	3,693,615,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	6,000,000.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	6,000,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,485,551,600.00</u>	<u>3,761,663,112.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,485,551,600.00	3,761,663,112.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,360,535,356.57	3,650,704,395.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,914,402,839.58	3,095,495,899.54
210101	Үндсэн цалин	1,573,225,539.58	1,535,893,544.91
210102	Нэмэгдэл	913,602,900.00	1,042,861,954.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	156,740,400.00	156,740,400.00
210104	Урамшуулал	250,200,000.00	360,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,634,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	322,358,485.87	365,159,759.72
210201	Тэтгэврийн даатгал	322,358,485.87	365,159,759.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,584,687.89	52,156,423.26
210301	Гэрэл, цахилгаан	31,893,909.00	33,313,400.00
210302	Түлш, халаалт	15,495,954.00	15,359,283.00
210303	Цэвэр, бохир ус	3,194,824.89	3,483,740.26
2104	Хангамж, бараа материалын зардал	16,067,279.36	24,846,663.94
210401	Бичиг хэрэг	3,920,760.00	12,001,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,330,000.00	6,557,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,305,302.36	3,299,763.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	780,000.00	816,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,731,217.00	2,171,600.00
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,759,564.00	51,980,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,409,974.00	1,175,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	990,000.00
210604	Урсгал засвар	12,349,590.00	49,815,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,257,999.87	60,765,649.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,400,100.00	42,325,960.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	3,900,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,258,000.00	2,377,915.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	309,500.00	274,375.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	97,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,228,699.87	1,228,699.00
210807	Газрын төлбөр	261,700.00	261,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,800,000.00	10,300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,500.00	300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,500.00	300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125,016,243.43	110,958,716.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,899,900.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,899,900.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,693,413.21	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,693,413.21	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	59,422,930.22	110,958,716.54
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,422,930.22	110,958,716.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=====	=====
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
6	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=====	=====
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дуусвар болсон санхүүгийн тайлан
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,753,678,238.38	14,217,322.85	2,508,164,598.21	4,259,730,963.02 -
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			12,767,100.00	12,767,100.00 -
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		-12,767,100		-12,767,100.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			7,067,334,002.99	-
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,753,678,238.38	1,450,222.85	4,571,936,504.78	11,327,064,966.01
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	96,298,120.00			96,298,120.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
Тайлант үеийн үр дүн			-1,621,553,814.35	-1,621,553,814.35
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.85	2,950,382,690.43	9,801,809,271.66

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дуусвар болсон санхүүгийн тайлан
/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,723,615,000.00	3,650,704,395.46	72,910,604.54	98.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,723,615,000.00	3,650,704,395.46	72,910,604.54	98.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,723,615,000.00	3,650,704,395.46	72,910,604.54	98.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,147,925,400.00	3,095,495,899.54	52,429,500.46	98.33
210101	Үндсэн цалин	1,585,582,100.00	1,535,893,544.91	49,688,555.09	96.87
210102	Нэмэгдэл	1,045,602,900.00	1,042,861,954.63	2,740,945.37	99.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	156,740,400.00	156,740,400.00	-	100.00
210104	Урамшуулал	360,000,000.00	360,000,000.00	-	100.00
210105	Гэрээт ажлын хөлс			-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	377,751,100.00	365,159,759.72	12,591,340.28	96.67
210201	Тэтгэврийн даатгал	377,751,100.00	365,159,759.72	12,591,340.28	96.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,856,100.00	52,156,423.26	7,699,676.74	87.14
210301	Гэрэл, цахилгаан	36,658,300.00	33,313,400.00	3,344,900.00	90.88
210302	Түлш, халаалт	19,694,400.00	15,359,283.00	4,335,117.00	77.99
210303	Цэвэр, бохир ус	3,503,400.00	3,483,740.26	19,659.74	99.44
2104	Хангамж, бараа материалын зардал	24,848,300.00	24,846,663.94	1,636.06	99.99
210401	Бичиг хэрэг	12,001,500.00	12,001,500.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	6,558,600.00	6,557,000.00	1,600.00	99.98
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,299,800.00	3,299,763.94	36.06	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	816,800.00	816,800.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,171,600.00	2,171,600.00	-	100.00
2105	Нормативт зардал	-	-	-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,990,000.00	51,980,000.00	10,000.00	99.98
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,175,000.00	1,175,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	990,000.00	10,000.00	99.00
210604	Урсгал засвар	49,815,000.00	49,815,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,944,100.00	60,765,649.00	178,451.00	99.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,326,200.00	42,325,960.00	240.00	100.00

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	3,900,000.00	100,000.00	97.50
210803	Даатгалын үйлчилгээ	2,378,000.00	2,377,915.00	85.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	309,500.00	274,375.00	35,125.00	88.65
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	140,000.00	97,000.00	43,000.00	69.29
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,228,700.00	1,228,699.00	1.00	100.00
210807	Газрын төлбөр	261,700.00	261,700.00	-	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,300,000.00	10,300,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	300,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	300,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,723,615,000.00	3,694,021,550.00	29,593,450.00	99.21
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,693,615,000.00	3,693,615,000.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,693,615,000.00	3,693,615,000.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	30,000,000.00	406,550.00	29,593,450.00	1.36
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,000,000.00	406,550.00	29,593,450.00	1.36
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	190.00	239.00	-49.00	125.79
620001	Удирдах ажилтан	3.00	2.00	1.00	66.67
620002	Гүйцэтгэх ажилтан	164.00	204.00	-40.00	124.39
620003	Үйлчлэх ажилтан	20.00	30.00	-10.00	150.00
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	190.00	240.00	-50.00	126.32
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	167.00	207.00	-40.00	123.95
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	20.00	30.00	-10.00	150.00
650010	Гэрээт ажилтан	3.00	3.00	-	100.00

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн	Аудитын код:
2019.02.20			САГ-2019/358/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Улаанбаатар хот дахь Гаалийн газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Тайлант оны эцэст НДШ-ийн тайлангаар 2,565.4 мянган төгрөгийн илүү төлөлттэй байгаа бөгөөд уг авлагыг санхүүгийн тайланд бусад байгууллагаас авах авлагаар тусгасан байна. Энэ нь тайлант хугацааны эцэст Нийгмийн даатгалын байгууллагтай тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс үүссэн байна.	2,565.4	Зөвлөмж өгөх	Санхүү албаны дарга	Д.Гантөмөр
	Дүн	2,565.4			